

Анги, бүлэг

Шифр:




8 ДУГААР АНГИЙН ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

“А” Хувилбар

Хугацаа 60 минут

СОНГОХ ДААЛГАВАР

1. Дараах хэмжилтүүдийн аль нь яг 20см^3 шингэнийг хэмжин авч буйг илэрхийлж байна вэ? 1 оноо



2. Дараах нэгдлүүдээс аль нь давс вэ? 1 оноо

A. Натрийн гидроксид

B. Хүхрийн хүчил

C. Магнийн сульфат

D. Натрийн оксид

3. Эерэг цэнэгтэй байдаг эгэл хэсэг аль нь вэ? 1 оноо

A. Электрон B. Нейтрон C. Атомын цөм D. Протон

4. Үелэх системийн бүлгийн дугаар юуг заадаг вэ? 1 оноо

A. Электрон дахрааны тоо

B. Гадаад давхраан дахь валентийн электроны тоо

C. Цахилгаан сөрөг чанар

D. Атомын радиусыг

5. Химийн элементийн үелэх хүснэгтийг хэн бүтээсэн бэ? 1 оноо

A. Д.И. Менделеев

B. Ж. Ньюлендс

C. И. Добрейнер

D. Ю.Л. Мейер

6. Дараах урвалуудаас халах урвалын жишээг сонгоно үү? 1 оноо

A. Кали + Хлор = Калийн хлорид

B. Төмөр + Зэсийн сульфат = Төмрийн сульфат + Зэс

C. Натрийн гидрокарбонат = натрийн карбогат + ус + нүүрсхүчлийн хий

D. Калийн хлорид + Мөнгөний нитрат = Калийн нитрат + Мөнгөний хлорид

7. Жижиг хэсгүүдийн мөргөлдөлтийн дүнд химийн урвал явагддаг. 1 оноо

A. Ашигтай мөргөлдөлт

B. Идэвхгүй мөргөлдөлт

C. Олон мөргөлдөлт

D. Бага мөргөлдөлт

8. Мөс хайлах нь ямар урвалын төрөл вэ? 1 оноо

A. Халах урвал

B. Экзотермийн урвал

C. Эндотермийн урвал

D. Дулаан ялгаруулах

9. Байгалийн усны бохирдлын эх үүсвэрт аль нь байхгүй вэ? 1 оноо

A. Химийн бохирдол

B. Бактерийн бохирдол

C. Агаарын бохирдол

D. Механик бохирдол

F. Физик бохирдол

10. Хэсэг сурагчид гялалзсан гоёмсог чулуу олж түүнийхээ нягтыг хэмжихээр шийджээ. Дараах багажуудаас алийг нь сонгох хэрэгтэй вэ? 1 оноо

A. Шувтан колбо ба шилэн аяга

B. Шувтан колбо ба жин

C. Шилэн аяга ба хэмжээст цилиндр

D. Хэмжээст цилиндр ба жин

11. Дараах урвалаар ямар давс үүсэх вэ? 1 оноо

Цайр + Азотын хүчил = + Устөрөгч

A. цайрын сульфат

B. цайрын нитрат

C. цайрын хлорид

D. цайрын карбонат

12. Фосфорын атомын масс нь 31, протоны тоо нь 15. Фосфорын атом хичнээн нейтроныг агуулах вэ? 1 оноо

A. 15

B. 16

C. 31

D. 40

13. VII бүлгийн элементүүдийн хайлах, буцлах цэгийн утга өгөгджээ. Бүлгийн дагуух зүй тогтлыг ажиглан бромын хайлах цэгийг баримжаална уу. 1 оноо

Элемент	Хайлах цэг, °C	Буцлах цэг, °C
Фтор	-220	-188
Хлор	-110	-34
Бром	?	59

- A. -223
B. -158
C. -7
D. 110

14. Металлын идэвхийн эгнээг үндэслэн хүхрийн хүчилтэй урвалд орж устөрөгч ялгаруулдаг металлыг сонгоно уу. 2 оноо

Li, K, Ba, Na, Ca, Mg, Zn, Fe, H, Cu, Ag, Au

A. Cu B. Ag C. Zn D. Au

15. Аль элемент нь устай хамгийн эрчимтэй урвалд орох вэ? 2 оноо

A. Лити B. Кальци C. Магни D. Цайр

16. Гурван хуруу шилэнд адил эзлэхүүнтэй давсны хүчлийн уусмал хэмжин авч тэнцүү масстай том, дунд зэрэг, нунтагласан 3 янзын хэмжээтэй шохойн чулууг тус бүр нэмжээ. Аль тохиолдолд урвал хурдан явагдах вэ? 1 оноо

- A. Том хэмжээтэй шохойн чулуу
B. Дунд зэргийн хэмжээтэй шохойн чулуу
C. Нунтагласан шохойн чулуу
D. Бүх шохойн чулуу ижил

17. Сурагч болд тодорхой хэмжээний аммонийн хлоридыг ус агуулсан стаканруу хийхэд усны температур 21°C-ээс 17°C болж буурчээ. Урвалын төрлийг олж, шалтгааныг тодорхойлно уу. 1 оноо

	Урвалын төрөл	Шалтгаан
A	Экзотерм	Дулаан ялгарсан
B	Экзотерм	Дулаан шингээсэн
C	Эндотерм	Дулаан ялгарсан
D	Эндотерм	Дулаан шингээсэн

18. Сурагч Билгүүн хүчиллэг бороо ургамлын өсөлтөд хэрхэн нөлөөлдгийг шинжлэхээр болжээ. Түүний хийж буй шинжлэх ухаанч үйлийг зөв дараалалд оруулаарай. 1 оноо

- I. Туршилтыг төлөвлөгөөний дагуу хийж үр дүнг диаграммаар илэрхийлэн, явц үр дүнг тайлбарласан.
II. Бид хийсэн туршилтаараа хүчиллэг бороо ургамлын өсөлтөд нөлөөлдөг болохыг баталлаа.
III. Ургамлын ургалтанд хүчлийн бороо нөлөөлдөг байх магадлалтай.
IV. Үр соёолуулах сав бэлтгэнэ. Хоёр төрлийн үр авч нэгийг энгийн усаар усалж, нөгөөг хүчиллэг болгосон усаараа усалж соёололтыг ажиглана.

A. I, II, III, IV B. II, I, III, IV C. III, IV, I, II D. III, IV, II, I

19. Агаарыг бохирдуулж буй тоосонцрыг PM гэсэн нэгжээр хэмждэг. Энэ нь тоосонцрын юуг илэрхийлсэн хэмжүүр болохыг сонгоно уу. 1 оноо

A. Диаметр B. Масс C. Концентрац D. Хорт чанар

20. Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийгбодис гэнэ. 2 оноо


A. Аюултай бодис B. Хортой бодис
C. Аюултай, хортой бодис D. Химийн найрлагатай бодис

21. Дараах нэмэлт бодисын тэмдэглэгээ зориулалтыг зөв харгалзуулна уу? 2 оноо

№	Тэмдэглэгээ	№	Зориулалт
1	E100-199	А	Бусад химийн нэмэлт
2	E200-299	Б	Үнэр амт нэмэгдүүлэгч
3	E600-699	В	Будагч
4	E1000-с дээш	Г	Хадгалалтын хугацааг уртасгагч

A. 1В,2Г,3Б,4А В. 2Г,1А,3В,4Б С. 4А,3Б,2В,1Г D. 4А,3Б,2В,1Г

22. Шингэний эзлэхүүнийг зөв хэмжих техникийг илэрхийлсэн хариултыг сонгоно уу. 1 оноо



23. Дараах давсны нэр болон гарган авах аргыг зөв харгалзуулна уу. 1 оноо

Давсны нэр

1. Сульфатын давс
2. Хлоридын давс
3. Нитратын давс


Давс гарган авах урвал

- а. Мөнгө + Давсны хүчил
- б. Магни + Хүхрийн хүчил
- в. Кальцийн карбонат + Нүүрсний хүчил
- г. Цайр + Давсны хүчил
- д. Зэсийн карбонат + Азотын хүчил

A. 1б 2г 3д В. 1а г 2б 3д С. 1б 2а г 3д D. 1д 2г 3б

24. Доорх зурагт зарим элементийн электрон хуваарилалтыг харуулав.

/x – ээр электрон давхраа бүрд байрлах электроныг тэмдэглэв/



Аль хоёр элементийн химийн шинж чанар төсөөтэй байх вэ? 1 оноо


A. 1 ба 2 В. 1 ба 3 С. 2 ба 3 D. 2 ба 4

25. Брант фосфорыг анх юунаас гарган авсан бэ? 1 оноо

A. Агаараас В. Хүний шээснээс С. Фосфорын оксидоос D. Фосфорын хүчлээс

ЗАДГАЙ ДААЛГАВАР

26. Дараах шил сав, багаж хэрэгслийг нэрлэнэ үү.



1.....1 оноо



2.....1 оноо



3.....1 оноо

